




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт





ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2021 онд: **5.1%**,
Инфляци: 2021 онд: **8.2%**,
Урсгал тэнцэл: 2021 онд: **-8.3%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2021 онд: **6%**
Инфляци: 2021 онд: **5.5%**,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2021 онд: **-13.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 8-р сарын байдлаар (1042) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 29.1 хувиар өссөн бол, зарлага 14.5 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1042 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 60.8 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 0.07 төгрөгөөр буурсан байна.

Наймдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс -0.20 төгрөгөөр буурч, өмнөх сартай харьцуулахад 0.07 төгрөгөөр буурч 2848.90 төгрөг болов. 7-р сард гадаад валютын нөөц 4.5 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 3 хувиар буурч, оны эхнээс 0.94 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 26.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 8.9%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны 8-р сарын байдлаар өмнөх сараас 0.4 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар, оны эхнээс 8.9 хувь өсөв. Инфляцын түвшин 2021 оны 8 дугаар сард улсын хэмжээнд хүнсний бараа, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ тус тус өссөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 1153 сая.ам долларын ашигтай гарав.

2021 оны наймдугаар сард нийт барааны эргэлт 10,101 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар нэмэгдсэн бол экспорт өмнөх сараас 25.6 хувь нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 29.5 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 1153 сая ам.долларын ашигтай гарав.



8-Р САРЫН ОНЦЛОХ: ДНБ



Эх сурвалж: www.1212.mn

ДНБ (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) энэ оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 19.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.7 (16 хувь) их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Мөн 2015 оны зэрэгцүүлэх үнээр 12.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 739 (6.3 хувь) тэрбум төгрөгөөр нэмэгдэв. ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний хагас жилд 9 хувиар багассан бол 2021 оны эхний хагас жилд 6.3 хувиар нэмэгдсэн байна. Улирлын нөлөөллийг арилган тооцсон, ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2021 оны 2 дугаар улиралд өмнөх улирлынхаас 5.1 хувиар багасжээ. ДНБ энэ оны эхний хагас жилд 6.3 хувиар нэмэгдсэний 2.7 пункт нь уул уурхай, олборлолтын, 1.4 пункт нь үйлчилгээний салбарт, 3 пункт нь бүтээгдэхүүний цэвэр татварт ногдож байна. ДНБ (эцсийн ашиглалтын аргаар тооцсон) оны үнээр 2021 оны эхний хагас жилд 19.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн 2.4 (14.2 хувь) их наяд төгрөгөөр нэмэгдэв. ДНБ-ий эцсийн хэрэглээнд 2021 оны эхний хагас жилд 67.4 хувь, хөрөнгийн нийт хуримтлалд 38.8 хувь, цэвэр экспортод -6.2 хувь нь зарцуулагдаж, өмнөх оны мөн үеийнхээс хөрөнгийн нийт хуримтлал 12.4 пунктээр нэмэгдэж, эцсийн хэрэглээ 15.3 пунктээр багасжээ.

САРЫН ОНЦЛОХ

НАЙМДУГААР САРД 100 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ИПОТЕКИЙН ЗЭЭЛ ОЛГОВ.

- Монголбанк энэ оны наймдугаар сард 60 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг банкуудад хуваарилж, холбогдох гэрээний дагуу банкууд өөрийн эх үүсвэрээр 40 тэрбумыг нэмж, нийт 100 тэрбум төгрөгийн ипотекийн хөтөлбөрийн зээл олгохоор шийдвэрлэв. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд энэ оны эхний 7 сард Монголбанк болон банкны эх үүсвэрээр нийт 554.4 тэрбум төгрөгийн зээлийг 7470 өрхөд олгожээ. Энэ онд сард дунджаар 78.6 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

ШАТАХУУНЫ ҮНЭ 2018 ОНООС ТОГТМОЛ ӨСӨВ.

- Шатахууны үнэ 2018 оноос тогтмол өсөн мөн оны 11 дүгээр сард "АИ-92" шатахууны дунджаар 1979 төгрөг болж, сүүлийн дөрвөн жилийн дээд түвшинд хүрч байжээ. Харин 2020 оны зургаадугаар сард 1386 төгрөг болж өнгөрсөн дөрвөн жилийн хамгийн бага түвшинд хүрснийг Үндэсний статистикийн хороо мэдээллэв. Газрын тосны дэлхийн зах зээл дэх үнийн өсөлтөөс шалтгаалан "АИ-92" шатахууны үнэ энэ оны долоодугаар сарын 2-нд дунджаар 300 төгрөг, энэ сарынхаа 30-нд мөн 300 төгрөгөөр нэмэгдэж 2050 төгрөгт хүрэв.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 8-р сар 2021 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 8-р сар 2021 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn